

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн Жаргалант сумын “Жаргалант ус дулаан түгээх станц” орон нутгийн
өмчит хувьцаат компанийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн
аудитын хураангуй тайлан

Аудитын код: ОРА-2024/09/НА-СТА-ОНА

Цахим хуудас:
www.audit.mn

Орхон аймаг
2024 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ц.Нармандах
Утас: 70353088 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Буян-Ундрах
Утас: 70355805 Цахим хаяг: buyanundrakhb@audit.gov.mn

Аудитор: Ц.Одгэрэл
Утас: 70357955 Цахим хаяг: odgerelts@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2024.03.15 № 91

танай _____-ны № _____-т

ОРХОН АЙМГИЙН ЖАРГАЛАНТ
СУМЫН ЖАРГАЛАНТ УС
ДУЛААН ТҮГЭЭХ СТАНЦ
ОРОН НУТГИЙН ӨМЧИТ
ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ЗАХИРАЛ Ж.ЭРДЭНЭ-ОЧИР
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Орхон аймгийн Жаргалант сумын Жаргалант ус дулаан түгээх станц орон нутгийн өмчит хувьцаат компанийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Жаргалант ус дулаан түгээх станц орон нутгийн өмчит хувьцаат компанийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Жаргалант ус дулаан түгээх станц орон нутгийн өмчит хувьцаат компани нь тайлант онд 330.0 сая төгрөгийн нүүрс худалдан авалтыг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар худалдан авсан боловч байгалийн давагдашгүй хүчин зүйлийн нөлөөгөөр эрс хүйтэрсний улмаас Орхон аймгийн Жаргалант сумын онцгой комиссын шийдвэрээр 21.9 сая төгрөгийн нүүрсийг шууд худалдан авалтын аргаар өөрийн хөрөнгөөр худалдан авсан байна.

Аудитын гол асуудал

Жаргалант ус дулаан түгээх станц орон нутгийн өмчит хувьцаат компани нь 829.8 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 1,275.9 сая төгрөгийн зардал гарган, 446.1 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 468.9 сая төгрөг болж төлөвлөснөөс 163.8 сая төгрөг буюу 53.6 хувиар давсан нь тайлант онд Орхон аймгийн эрчим хүчний зохицуулах зөвлөлийн тогтоолоор үйлчилгээний үнэ тарифт өөрчлөлт орсноос шалтгаалжээ.

Нийт зардлын гүйцэтгэл 1,275.9 сая төгрөг болж, төлөвлөснөөс 924.0 сая төгрөг буюу 262.5 хувиар илүү гүйцэтгэлтэй байна. Энэ нь "Бизнес төлөвлөгөө"-нд зардлын төлөвлөлтийг дутуу тусгасан, цалингийн өсөлт, үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлын өсөлт зэрэг нь гол нөлөө үзүүлсэн байна.

Тайлант онд алдагдал 446.1 сая төгрөг болж, төлөвлөснөөс 185.1 сая төгрөгөөр илүү байгаа нь дээрх зардлын өсөлтөөс шалтгаалсан байна.

Бусад асуудлын хэсэг

Компанийн 2023 оны гүйцэтгэлийн тайланд аймгийн Засаг даргын орлогчийн 2024 оны А/90 дүгээр захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг "Хангалттай" үнэлгээ өгсөн байна.

Тухайн аудитыг хийх явцад аудитын дүгнэлт, тайлантай холбогдуулан аудит гүйцэтгэж буй аудитор аливаа этгээдийн нөлөөлөл, мэдээллийн нууцлал, ёс зүйтэй холбоотой холбогдох хуулийн дагуу мэдэгдлүүдийг гарган баталгаажуулсан болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРМАНДАХ



Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	БАЛАНСЫН ЗҮЙЛ	2022 оны 12 сарын 31	2023 оны 12 сарын 31
А	Б	1	2
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	4,860,773.00	14,497,789.17
1.1.2	Дансны авлага	-	-
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	-	13,483,593.00
1.1.4	Бусад авлага	2,941,299.00	24,180,550.00
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	-	-
1.1.6	Бараа материал	32,095,560.00	5,922,000.00
	Эргэлтийн хөрөнгийн дүн	39,897,632.00	58,083,932.17
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	4,081,183,022.88	4,282,101,500.32
1.2.2	Биет бус хөрөнгө	-	-
1.2.1	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	4,081,183,022.88	4,282,101,500.32
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	4,121,080,654.88	4,340,185,432.49
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ		
2.1	ӨР ТӨЛБӨР		-
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	-	-
2.1.1.2	Цалингийн өглөг	-	-
2.1.1.3	Татварын өр	-	5,952,446.61
2.1.1.4	НДШ-ийн өглөг	-	115,386.42
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	-	21,900,000.00
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	-	27,967,832.56
2.1.2.10	Өр төлбөрийн нийт дүн	-	27,967,833.03
2.3	2. Эзэмшигчийн өмч		
2.3.1	Төрийн өмч	-	-
2.3.2	Хувийн өмч	4,172,689,471.11	4,809,936,439.20
2.3.3	Хувьцаат	-	-
2.3.4	Халаасны хувьцаа	-	-
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	-	-
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	-	-
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	-
2.3.8	Эздийн өмч бусад хэсэг	-	-
2.3.9	Хуримтлагдсан ашиг:	(51,608,816.23)	(497,718,839.74)
2.3.11	Эздийн өмчийн дүн	4,121,080,654.88	4,312,217,599.46
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	4,121,080,654.88	4,340,185,432.49

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2023 оны 12 сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	468,943,750.89
2	Борлуулалтын өртөг	360,849,000.00
3	Нийт ашиг /алдагдал/	116,314,151.44
4	Түрээсийн орлого	-
5	Хүүний орлого	40,812.16
6	Борлуулалтын орлого	468,902,938.73
7	Эрхийн шимтгэлийн орлого	-
8	Бусад орлого	360,849,000.00
9	Борлуулалт, маркетингийн зардал	429,685,651.58
10	Ерөнхий ба удирдлагын зардал	485,364,041.60
11	Санхүүгийн зардал	-

12	Бусад зардал /ҮАБЗ/	-
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-
17	Бусад ашиг (алдагдал)	-
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(446,105,942.29)
19	Орлогын татварын зардал	4,081.22
-	Тайлангийн үеийн орлогын татварын зардал	4,081.22
-	Хойшлогдсон татварын зардал /орлого/	-
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(446,110,023.51)
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал/	(446,110,023.51)
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-
23.3	Бусад олз (гарз)	-
24	Орлогын нийт дүн	(446,110,023.51)
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг /алдагдал/	

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2023 оны 12 сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	837,158,608.09
	1.1.1 Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	476,258,157.09
	1.1.2 Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-
	1.1.3 Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	-
	1.1.5 Татаас, санхүүжилтийн орлого	360,849,000.00
	1.1.6 Бусад мөнгөн орлого	51,451.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	818,898,522.87
	1.2.1 Ажилчдад төлсөн	202,751,440.14
	1.2.2 Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	63,130,680.49
	1.2.3 Бараа материал худалдан авахад төлсөн	350,475,300.00
	1.2.4 Ашиглалтын зардалд төлсөн	62,347,793.00
	1.2.5 Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	28,600,000.00
	1.2.7 Татварын байгууллагад төлсөн	31,046,162.17
	1.2.8 Бусад мөнгөн зарлага	80,547,147.07
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	18,260,085.22
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	36,730.95
	2.1.1 Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-
	2.1.2 Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-
	2.1.3 Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	-
	2.1.4 Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	-
	2.1.5 Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	-
	2.1.6 Хүлээн авсан хүүний орлого	36,730.95
	2.1.7 Хүлээн авсан ногдол ашиг	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	8,659,800.00
	2.2.1 Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө	8,659,800.00
	2.2.2 Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө	-
	2.2.3 Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн мөнгө	-
	2.2.4 Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө	-
	2.2.5 Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	8,623,069.05

3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-
	3.1.1 Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-
	3.1.2 Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-
	3.1.3 Төрөл бүрийн хандив	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-
	3.2.1 Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	-
	3.2.2 Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-
	3.2.3 Хувьцаа буцаан авахад төлсөн	-
	3.2.4 Төлсөн ногдол ашиг	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-
4	Вальютын ханшын зөрүү	-
4.1	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	9,637,016.17
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	4,860,773.00
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	14,497,789.17

2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2022 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	4,172,689,471.11	(51,608,816.23)	4,121,080,654.88
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			
3	Залруулсан үлдэгдэл	4,172,689,471.11	(51,608,816.23)	4,121,080,654.88
4	Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал/		(446,110,023.51)	(446,110,023.51)
5	Бусад дэлгэрэнгүй орлого			
6	Өмчид гарсан өөрчлөлт	637,246,968.09		637,246,968.09
7	Зарласан ногдол ашиг			
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн			
9	2023 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	4,809,936,439.20	(497,718,839.74)	4,312,217,599.46

Гурав. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 22,805.8 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 22,805.8 мянган төгрөгийн алдааг залруулж тайлагналаа.

Залруулсан алдаа:

- Мөнгөн гүйлгээний тайланд тайлант онд худалдан авсан 8,659.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг хөрөнгө оруулалтын мөнгөн зардлаар тайлагнаагүй нь аудитын ангилал, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангаагүй тул мөнгөн гүйлгээний тайланд залруулав.
- Нэмэгдсэн өртгийн албан татварын 13,483.6 мянган төгрөгийн авлагыг санхүүгийн тайланд тусгаагүй нь аудитын иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангаагүй тул санхүүгийн байдлын тайланд залруулав.
- Хувь хүний орлогын албан татварын өглөгийг 662.4 мянган төгрөгөөр зөрүүтэй тусгасан нь аудитын үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангаагүй тул санхүүгийн байдлын тайланд залруулав.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

Аудитаар нийт 6,104.3 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 6,104.3 мянган төгрөгийн зөрчилд 7 төлбөрийн акт тогтоож, 5 зөрчилд зөвлөмж өгсөн.

3.1 Төлбөрийн акт

Анхан шатны баримтгүй томилолтын зардал зарцуулсан, ээлжийн амралтын нөхөн олговор авсан ажилтанд цалин давхардуулан олгосон, үндсэн ажлын газраас бусад хуулийн этгээдтэй байгуулсан гэрээний үндсэн дээр ажил, үүрэг гүйцэтгэж авсан хөдөлмөрийн хөлснөөс албан татварын хөнгөлөлт эдлүүлсэн, сахилгын шийтгэлтэй ажилтны цалингаас суутгал хийлгүй цалин олгосон, шатахууны урамшууллыг бүртгэл тайланд тусгалгүй хувийн хэрэглээнд зарцуулсан, эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр ажилласан жилийн нэмэгдэл олгосон зэрэг нийт 6,104.3 мянган төгрөгийн зөрчилд 7 төлбөрийн акт тогтоов.

3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Мөнгөн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт 1:

Худалдан авч орлогоор бүртгэсэн бараа, ажил үйлчилгээний тоо хэмжээ, үнийн дүнг цахим төлбөрийн баримтад нийт дүнгээр бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын 6.5-д "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 "Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага"-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Худалдан авалт хийхдээ төлбөрийн баримт, нэхэмжлэхийг ажил үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ зэргийг бараа, ажил үйлчилгээ тус бүрээр авч байх.

2. Урсгал зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт 2:

Эд хөрөнгө хариуцагч солигдоход тооллого хийж, тооцоо бодоогүй, эд хариуцагчийн карт хөтлөөгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.2-д "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ", 12.2.2-д "эд хөрөнгө хариуцагч болон эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед", 20.2-д "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Эд хөрөнгө хариуцагч болон эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед тооллогын хийж, Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 347 дугаар тушаалаар баталсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах.

Илрүүлэлт 3:

Байгууллагын удирдлага ээлжийн амралтын хуваарийг журамд заасан хугацаанд батлаагүй, ажилтанд ээлжийн амралт олгохдоо "Ээлжийн амралт олгох мэдэгдэл" олгодоггүй байна.

Энэ нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/191 дүгээр тушаалаар баталсан "Ээлжийн амралт олгох, ээлжийн амралтын цалин тооцох журам"-ын 1.2-д "Ажил олгогч нь тухайн ажлын жилийн ээлжийн амралтын хуваарийг ажилтны саналыг үндэслэн ажил, үйлчилгээ, үйлдвэрлэлийн хэвийн үйл ажиллагааг алдагдуулахгүй байдлаар зохион байгуулж, жил бүрийн нэгдүгээр улиралд батална", 1.3-д "Ажил олгогч ээлжийн амралтын хуваарийн дагуу энэхүү журмын нэгдүгээр хавсралтаар баталсан "Ээлжийн амралт олгох мэдэгдэл"-ийг байгууллагын холбогдох нэгж болон ажилтанд олгоно" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/191 дүгээр тушаалаар баталсан "Ээлжийн амралт олгох, ээлжийн амралтын цалин тооцох журам"-ыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах.

3. Санхүүгийн тайлагналтай холбоотой асуудал

Илрүүлэлт 4:

Тус компани нь санхүүгийн үйл ажиллагаандаа өөрийн онцлогт тохирсон санхүүгийн тайлан бэлтгэхэд баримтлах нягтлан бодох бүртгэлийн зарчим, горимыг тодорхойлсон "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг батлуулж мөрдөөгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3.1.9-д "нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг" гэж бүртгэлийн суурь, санхүүгийн тайлан гаргахад баримтлах зарчмыг тодорхойлсон журам, заавар, аргачлалыг багтаасан баримт бичгийг", 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 18.2-т "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана", 20.2-т "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ", 20.2.2-т "аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар" болон бусад хууль тогтоомжид нийцсэн "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг батлуулж мөрдөх.

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Жаргалант ус дулаан түгээх станц ОНӨХК	3	22,805.8	2	22,143.4	1	662.4	3	22,805.8				
Дүн	3	22,805.8	2	22,143.4	1	662.4	3	22,805.8				

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Жаргалант ус дулаан түгээх станц ОНӨХК	11	6,104.3	7	6,104.3			4	-				
Дүн	11	6,104.3	7	6,104.3			4	-				

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Жаргалант ус дулаан түгээх станц ОНӨХК	1	-					1	-
Дүн	1	-					1	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Жаргалант ус дулаан түгээх станц ОНӨХК								
Дүн								
Нийт дүн	1	-					1	-

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1			1			